МЭДЭЭ · 2026 оны 1-р сарын 26

ХҮН ХУДАЛДААЛАХ ХЭРГИЙГ ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Прокурорын байгууллага 2026 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс 23-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 47,803 эрүүгийн хэрэгт хяналт тавин ажиллажээ.

Дээрх хугацаанд 1,184 гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл бүртгэгдсэн бол хэрэг бүртгэлтийн 750 хэрэг шинээр нээж, 206 хэрэгт прокурор яллах дүгнэлт үйлдсэн байна.

Яллах дүгнэлт үйлдсэн хэргийг тодруулбал, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 78, Өмчлөх эрхийн эсрэг 32, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 73, Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг тус бүр 5, Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг, Авлигын гэмт хэрэг тус бүр 4, Хүрээлэн байгаа орчны эсрэг болон Эдийн засгийн гэмт хэрэг тус бүр 2, Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1 байна.



Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн зарим хэргээс дурдвал:

-Б.Г нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа эрх мэдэл албан тушаалын байдлаар урвуулан ашиглаж, Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан иргэдийн төлбөрийг өөрийн хувийн дансаараа авсан, итгэмжлэн хариуцуулсан 1 ширхэг галт зэвсгийг гэртээ хадгалж, хувьдаа завшсан хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлийн 1 /Хөрөнгө завших/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Дүүргийн Эрүү Иргэний хялбар ажаиллагааны анхан шатны тойргийн шүүхэд,

-Г.Г нь нийтийн албан тушаалтнаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж орон нутгийн удирдлагын тогтоол, шийдвэрээр нэр бүхий компанийн нэр дээр олгогдсон газрын зориулалтыг болон байршлыг хууль бусаар өөрчлөн газрыг хэсэгчлэн бусдад шилжүүлэн, давуу байдал бий болгосон хэрэгт Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Өмнөговь аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд,

-С.З нь фэйсбүүк цахим хаягаараа насанд хүрээгүй хүнтэй харилцаж, “нүцгэн видео дуудлага хийвэл мөнгө өгнө” хэмээн, харилцах явцдаа зургийг нь авч, мөнгө өгөхгүй бол нууцыг нь чинь дэлгэнэ хэмээн сүрдүүлсэн хэрэгт Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн 2.1 /Бэлгийн мөлжлөг/, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 2.1 /Хүн худалдаалах/, Эрүүгийн хуулийн 13.5 дугаар зүйлийн 1 /Заналхийлэх/, Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлийн 1 /Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

-Х.Н нь нэр бүхий охидын биеийг нь үнэлүүлэх зорилгоор “Малайз улсад өндөр цалинтай ажил байна, би замын зардлыг нь даана, цалин дээрээсээ суутгуулж болно” гэж хууран мэхэлж, эдийн засгийн эмзэг байдлыг нь далимдуулан хил нэвтрүүлж, эрхшээлдээ оруулан, бусдад дамжуулсан хэрэгт Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн 2.2, 2.3 /Хүн худалдаалах/, Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлийн 2.3 /Хүн хулгайлах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд,

-Нэр бүхий компаний захирал Д.Д нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө жоншны агууламжийг тодорхойлох зорилгоор холбогдох газраас Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодис ашиглах дүгнэлт гаргуулж, ашиглах зөвшөөрөл авалгүйгээр, “Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалт”-ад багтсан цууны хүчил, каолийн гидроксид, этилийн спирт, хүхрийн хүчил зэрэг бодисуудыг гадаад улсаас захиалан хууль бусаар авч, хадгалсан хэрэгт Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 1,3 /Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Хэнтий аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд,

-Гадаад улсын иргэн В.Л нь хилийн боомт бус газраас явганаар Монгол Улсад хил нэвтрэх эрхийн баримт бичиггүйгээр, зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийг нэвтэрсэн хэрэгт Эрүүгийн хуулийн 19.14 дүгээр зүйлийн 1 /Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж Хөвсгөл аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд,

-Г.М нар нь НҮБ-ын 1971 оны конвенцын II жагсаалтад багтсан шингэн төрлийн хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг худалдаалах зорилгогүйгээр хууль бусаар олж авсан, хадгалсан, Б.З, З.О нар нь 18.7 грамм хэмжээтэй шингэн төрлийн хориглосон сэтгэцэд нөлөөт бодисыг бусдад худалдсан хэрэгт, Г.Н нь НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенцын II жагсаалтад багтсан метамфетаминийн агууламжтай “мөс” гэх нэршилтэй сэтгэцэд нөлөөт бодисыг бусдад худалдсан хэргүүдэд Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 1 /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/-д зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхэд шилжүүллээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/613